

ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ “ЁС ЗҮЙН ӨДӨРЛӨГ” ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ


ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлөөс 2021 оны 4 сарын 5-12-ны өдрүүдэд “Ёс зүйн өдөрлөг” аяныг бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтныг хамруулан зохион байгууллаа. Дэлхийн хэмжээнд тархсан цар тахал Covid-19 нөлөөгөөр улс даяар хөл хөдөлгөөнийг хязгаарласантай уялдуулан цахим орчныг ашиглан дараахь чиглэлээр ажиллалаа.

1. ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрмийн танилцуулга, сурталчилгааны баннерыг “Энэ дүрэм хэнд хамаарах вэ?”, “Ажилтан, удирдах ажилтны баримтлах ёс зүйн хэм хэмжээ”, “Багшийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ёс зүйн хэм хэмжээ”, “Багшлах үүргээ хэрэгжүүлэх ёс зүйн хэм хэмжээ”, “Багшийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх ёс зүйн хэм хэмжээ”, “Зөрчил 2016-2020” гэсэн агуулгаар бэлтгэж, ШУТИС-ийн “Багшийн веб”-д байршуулж, “ШУТИС-ийн багш” болон бүрэлдэхүүн сургуулийн веб хуудас, фэйсбүүк группээр дамжуулан танилцуулсан.




Зураг 1. "ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрмийн танилцуулгыг багшийн веб болон бүрэлдэхүүн сургуулийн веб хуудас, фэйсбүүкд байршуулсан баннер

2. “Таны ёс зүйн боловсролд” сэдвийн хүрээнд Ёс суртахууны боловсрол гэж юу вэ?, Ёс зүй ба ёс суртахуун гэж юу вэ?, Ёс суртахууны хэм хэмжээ гэж юу вэ?, Ёс суртахууны зарчим гэж юу вэ?, Ёс суртахууны ойлголтууд, Ёс суртахууны үнэлэмж, Мэргэжлийн ёс зүйн тухай зэрэг ёс суртахуун, ёс зүйн талаарх эрдэмтэд судлаачдын үзэл баримтлалтай холбоотой мэдээллийг цувралаар бэлтгэн “ШУТИС-ийн багш” фэйсбүүк групп болон бүрэлдэхүүн сургуулийн фэйсбүүк группийг ашиглан багш, ажилтнуудад хүргэлээ.



Зураг 2. “Таны ёс зүйн боловсролд” сэдвийн хүрээнд “ШУТИС-ийн багш” фэйсбүүк групп болон бүрэлдэхүүн сургуулийн фэйсбүүк группээр хүргэсэн мэдээллийн жишээ

3. “Эх орон” телевизийн “Зөвийн тухай ярилцъя” сэдэвт 11 цуврал нэвтрүүлгийг “ШУТИС-ийн багш” фэйсбүүк группд оруулж, ёс суртахууны боловсрол олгох мэдээллийг түгээн ажиллалаа.



Зураг 2. “Зөвийн тухай ярилцъя” сэдэвт 11 цуврал нэвтрүүлгийг “ШУТИС-ийн багш” фэйсбүүк хуудсаар түгээсэн байдал

4. "Багш мэргэжлийн ёс суртахууны манлайлал" сэдвээр Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор Н.Цолмонтауяаг урьж оролцуулсан цахим лекцэд ШУТИС-ийн нийт 156 багш, ажилтан хамрагдаж, ёс суртахуун, манлайллын талаар мэдээлэл авлаа.

Зураг 3. "Багш мэргэжлийн ёс суртахууны манлайлал" цахим лекц



5. "БИД ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭНЭ" (facebook frame) хүрээг БУХС-55, ГХС-70, ГУУС-35, ҮТС-50, ДТС-54, МТС-69, ЭХС-17, ХШУС-50 зэрэг 500 гаруй профессор багш, ажилтан ашиглаж тус өдөрлөгт цахимаар нэгдэн оролцлоо.



Зураг 4. "БИД ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭНЭ" (facebook frame) хүрээг ашиглан цахим орчинд нэгдсэн ШУТИС-ийн багш, ажилтнууд

“ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн өдөрлөг” аянд идэвхтэй хамрагдаж цахимаар нэгдсэн нийт багш, ажилтан та бүхэнд талархал илэрхийлье.

“БИД ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭНЭ”

ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ